



GMIT RESEARCH AND LABORATORIES - МГТИС-ИЙН СУДАЛГАА БА ЛАБОРАТОРИ



GERMAN - MONGOLIAN INSTITUTE  
FOR RESOURCES AND TECHNOLOGY



“Шинжлэх ухааны үзэл санааны гол хэмжүүр бол сэтгэлгээг тэлэн судалгааны шинэ санааг нээж өгдөг”

Паул А.М.Дайрэк- физик

“The measure of greatness in a scientific idea is the extent to which it stimulates thought and opens up new lines of research.”

Paul A.M. Dirac – Physicist

The German-Mongolian Institute for Resources and Technology (GMIT) emphasises applied and interdisciplinary research activities, with a special focus on clean air, clean water, and clean soil. Right now, our faculty and students are conducting more than 10 research projects, for example:

- GLEAR – Clean Air for Gers
- Integrated Water Resource Management
- Further Development of Air Quality Planning and Air Quality Monitoring in Ulaanbaatar
- Environmental Impacts of Small Scale Mining in Nailakh
- Optimisation of the Value Chain for Polymimetal Ores of Economically Strategic Metals
- Thermal Coatings for Tribologically Highly Loaded Machine Parts
- Sulfur Removal Process of Coal by Using an Efficient Electromchemical Method



Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь салбар хоорондын судалгаа шинжилгээний үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэр дундаа цэвэр агаар, цэвэр ус, цэвэр хөрсний чиглэлд онцгой анхаарал хандуулдаг.

Одоогийн байдлаар манай багш, оюутнууд судалгааны 10 гаруй төсөл хэрэгжүүлж байна.  
Тухайлбал,

- "GLEAR" төсөл - Утаагүй зуухны төсөл
- Усны нөөцийн нэгдсэн менежмент
- Улаанбаатар хотын агаарын чанарын хяналт төлөвлөгөө болон агаарын чанарын хяналт шинжилгээг сайжруулах нь
- Налайхын бичил уурхайн үйл ажиллагаа ба түүнээс үүдэх байгаль орчны нөлөө
- Полиминерал хүдрийн метал дахь гинжин холбоог оновчтой болгох
- Их үрэлтээ машины эд ангийг лазер болон дулааны аргаар бүрэх технологи
- Электрохимийн аргаар нүүрснээс хүхэр гаргаж авах үйл явц

## **Why is it relevant to you that GMIT faculty are involved in research?**

Because, there has several advantages to enrolling in a research university like GMIT.

- **Top researchers are top teachers:** Our faculty members carry their passion for research into the classroom and are inspirational teachers. Those who do research can explain study subjects much better to students - especially when it comes to more advanced modules and topics.
- **No boring lectures:** Our faculty members include recent research discoveries in their classes. This makes classes more lively and exciting than teaching out of textbooks.
- **Faculty are more energised:** Our faculty members receive academic recognition for their research work; for example, publications in distinguished scientific journals or participation in domestic and international conferences. Furthermore, as a research university, GMIT organises workshops and international conferences on campus, bringing the most up-to-date information and practices to its teaching. The "International Conference on Environmental Science and Engineering" in August 2018 is a recent example. On monthly basis, GMIT invites renowned scientists to give guest lectures on their academic research, which GMIT students are able to attend.
- **Internships and collaborative research:** The best educational experience for students takes place in the context of shared research activities and during practice-oriented internships. Solving real-world problems, in collaborative research projects, is inspiring and motivating for students.

## **МГТИС-ийн судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа танд яагаад хамаатай вэ?**

Учир нь судалгаа шинжилгээний их сургууль МГТИС-д элсэн суралцах нь олон давуу талтай.

- **Шилдэг судлаачид бол шилдэг багш нар:** Манай багш нар сургалтандaa судалгааг хослуулдаг нь оюутнуудад ихээхэн тус болдог. Ялангуяа, мэргэжлийн, гүнзгийрүүлсэн сургалтад судлаач багш нарын арга барил илүү сайн байдаг.
- **Ямар ч уйтгартай лекц байхгүй!** Багш нар маань сургалтандaa хамгийн сүүлийн үеийн судалгаа шинжилгээний ажлаа багтаадаг. Тийм ч учраас хичээлүүд сурх бичигтэй ажиллахаас илүүтэй сонирхолтой, бодит байдаг.
- **Багш нар маань үргэлж хөгжиж байдаг:** Манай багш нар судалгааны ажлуудаараа салбартаа хүлээн зөвшөөрөгддөг. Тухайлбал, тэдний эрдэм шинжилгээ, судалгааны ажил дотоодын болон олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлэгддэг төдийгүй олон улсын бага хурлуудад оролцдог. Цаашилбал, МГТИС нь сургалт семинарууд болон олон улсын бага хурлыг өөрсдийн хотхондоо зохион байгуулдаг бөгөөд ингэснээр багш нарын мэдлэг, ур чадвар хамгийн сүүлийн үеийн мэдээлэл, туршлагаар хөгжиж байдаг юм. 2018 оны 8 дугаар сард МГТИС нь "Байгаль орчны шинжлэх ухаан ба инженерчлэл" олон улсын бага хурал зохион байгуулахаар ажиллаж байна. Түүнчлэн олонд танигдсан эрдэмтдийг сургууль дээрээ урьж, тэдний судалгааны талаар сар бүр лекц зохион байгуулдаг бөгөөд оюутнуудад ч нээлттэй байдаг.
- **Дадлага ба хамтын судалгаа:** Оюутнуудын хувьд боловсрол эзэмших нэгэн шилдэг туршлага бол хамтарсан судалгааны үйл ажиллагаанд оролцох болон практикт сууриссан дадлагын ажил хийх байдаг. МГТИС оюутнууддаа хамтын судалгааны төслүүдэд оролцож, бодит амьдрал дээрх асуудлыг шийдэх боломж олгодог нь тэдний суралцах урам зоригийг хөгжөөж байдаг юм.

## **Join a research-oriented university like GMIT. Take the right decision.**

In 2018, GMIT expanded its research support activities. In order to develop and support young researchers over the long-term, GMIT initiated a research funding programme in close cooperation with the Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ). This Strategic Research Development Fund supports university instructors and professors at GMIT as well as young student researchers in the following ways:

- Setting up and expanding key areas of research that will further enhance the profile of the university (teaching and research)
- Providing research support at all levels (BA, MA, and Ph.D. students, post-doctoral trainees)
- Funding innovative research projects of GMIT students.

Regarding the project goal and content, preference will be given to interdisciplinary, applied research proposals within the GMIT's core research area.



**Судалгаанд суурилсан МГТИС-т элсэн суралцаж, бидэнтэй нэгдэхийг урьж байна. Оновчтой шийдвэр гаргаарай.**

2018 онд МГТИС нь судалгааны үйл ажиллагаагаа өргөжүүлж залуу судлаачдыг урт хугацаанд дэмжих зорилгоор Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран судалгааны санхүүжилтүүн хөтөлбөрийг эхлүүлээд байна. Энэхүү Стратегийн судалгааны сан нь МГТИС-ийн эрдэмтэн, багш болон залуу, оюутан судлаачдад дараахь дэмжлэгүүдийг үзүүлэх юм. Үүнд,

- Судалгааны үндсэн чиглэлүүдийг бий болгох, өргөжүүлэх. Ингэснээр МГТИС-ийн сургалт, судалгааны үйл ажиллагааг улам бүр сайжруулна.
- Бакалавр, магистр, доктор болон докторын дараахь сургалтын түвшин бүрт судалгааны дэмжлэг үзүүлэх.
- МГТИС-н оюутнуудын шинэ санал санаачилга бүхий судалгааны төслүүдийг санхүүжүүлэх.

МГТИС-ийн гол судалгааны чиглэлүүдийн хүрээнд хийгдсэн судалгааны төслийн саналуудыг төслийн зорилго, агуулгаас хамааран санхүүжүүлэх юм.





МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ  
МАЛТМАЛ ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

GMIT Campus, 2<sup>nd</sup> Khoroo, Nalaikh district, Ulaanbaatar

Tel: +976 7023 2086

admission@gmit.edu.mn

[www.gmit.edu.mn](http://www.gmit.edu.mn)

The development of GMIT and its cooperation with German Partner Universities is supported by the Mongolian Ministry of Education, Culture, Sciences, and Sports, and the Federal Government of Germany. The German contribution to GMIT is implemented by the Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) and the German Academic Exchange Service (DAAD).

МГТИС-ийн хөгжил болон Германы хамтрагч их дээд сургуулиудын хамтын ажиллагаа зэргийг хоёр улсын Засгийн газар дэмжин ажилладаг. Монгол Улсаас БСШУСЯ болон ХБНГУ-аас Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Германы эрдмийн солилцооны алба (DAAD)-наас хариуцан, хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллаж байна.



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
  
БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



Хэрэгжүүлэгч:

**giz**

Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

**DAAD**

Deutscher Akademischer Austauschdienst  
German Academic Exchange Service